

2

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Бадамцэцэг

Үндэсний баялаг гэдэг нь нэлээд өргөн ойлголт бөгөөд байгалийн нөөц баялаг, хүмүн болоод нийгмийн капитал, үйлдвэрлэсэн хөрөнгийг илэрхийлдэг.

Хүний нөөцөд боловсрол, ур чадваргүй ажиллах хүч, харин үйлдвэрлэсэн хөрөнгөд машин, тоног төхөөрөмж, барилга байшин, хотын газар хамаарах бөгөөд хүний нөөц нь хамгийн чухал, давамгайлах үүрэгтэй байна.

Үндэсний баялгийг дараахи үндсэн 3 бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцно. Үүнд:

- Байгалийн нөөц баялаг
- Үйлдвэрлэсэн хөрөнгө
- Хүний нөөц

Байгалийн нөөц баялаг нь ХАА-н газар, бэлчээрийн талбай, бизнесийн болон бизнесийн бус зориулалттай ойн баялаг, дархан цаазтай газар, газрын тос, нүүрс, байгалийн хий, металл болон эрдэс баялаг зэрэг сэргээгдэх болон сэргээгдэхгүй нөөцөөс бүрдэнэ.

Үйлдвэрлэсэн хөрөнгө нь тухайн орны машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж болон хотын газрын нийлбэр юм.

Хүний нөөцийг ХАА-н болон ХАА-н бус салбарын “хөдөлмөрийн өгөөж” хэмээн үзэж болох ҮНО-ын хувийг тооцох замаар буюу хүн амын бүтээлч жилүүдийн дунджуудын өнөөгийн үнэ цэнээс үйлдвэрлэсэн хөрөнгө болон хотын газрыг хасаад гарах үлдэгдлээр тооцно. Энэ хэсэгт нийгмийн капиталын өгөөж орно.

Ур чадваргүй ажиллах хүч, хүмүүн болон нийгмийн капиталыг нэгтгэсэн хүний нөөц нь үндэсний баялгийн хамгийн чухал хэсэг болдог нь сонин биш юм. Хамгийн түрүүнд ямар зүйлийг онцлох ёстой вэ гэхээр байгалийн нөөц баялаг нь байгаль орчны үнэлгээн дээр тулгуурласан бөгөөд ингэхдээ экологийн болон амьдралыг тэтгэгч байгалийн чухал системүүд нь үнэлэгдээгүй байсан юм. Үүнийг үнэлгээний арга нь хэрэглээний утгад зориулагдан илүү хөгжсөнтэй холбон тайлбарласан байна.

Ойролцоогоор 100 орчим улсын баялгийн бүрэлдэхүүн хэсгийг тооцсон ба эдгээр улсуудыг сонгохдоо шаардагдах мэдээллийн чанарыг харгалзан үзэж сонгосон байна.

Нэг хүнд ногдох баялаг болон баялгийн бүрэлдэхүүн хэсгийг үзүүлсэн үндсэн үр дүнг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Нэг хүнд ногдох баялгийн хэмжээ, бүс нутгаар

	Нийт баялаг	Хүний нөөц	Үйлдвэрлэсэн хөрөнгө	Байгалийн нөөц	Хүний нөөц	Үйлдвэрлэсэн хөрөнгө	Байгалийн нөөц
	Нэг хүнд ногдох хэмжээ, ам.доллараар				Баялагт эзлэх хувь хэмжээ		
Хойд Америк	326,000	249,000	62,000	16,000	76	19	5
ЭЗХАХБ	302,000	205,000	90,000	8,000	68	30	2
Баруун Европ	237,000	177,000	55,000	6,000	74	23	2
Ойрхи Дорнод	150,000	65,000	27,000	58,000	43	18	39
Өмнөд Америк	95,000	70,000	16,000	9,000	74	17	9
Хойд Америк	55,000	38,000	14,000	3,000	69	26	5
Төв Америк	52,000	41,000	8,000	3,000	79	15	6
Карибын орнууд	48,000	33,000	10,000	5,000	69	21	11
Зүүн Ази	47,000	36,000	7,000	4,000	77	15	8
Зүүн Өмнөд Ази	30,000	20,000	7,000	3,000	66	25	10
Баруун Африк	22,000	13,000	4,000	5,000	60	18	21
Өмнөд Ази	22,000	14,000	4,000	4,000	65	19	16

Эх сурвалж: Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Дэлхийн ихэнхи улс орнуудад Үндэсний баялгийн дийлэнхи хувийг хүний нөөц эзэлж буйг судалгааны явцад тогтоосон байна. Бүс нутгуудын хувьд харилцан адилгүй байгаа боловч нийт баялгийн дотор 40-80 хувийг хүний нөөц эзэлж байна.

Байгалийн баялгийн эзлэх хувь 2-40 хувийн хооронд хэлбэлзэж байна. Аж үйлдвэржсэн орнуудын байгалийн капиталын эзлэх хувь бага байгаа нь ямар нэг буруу ташаа ойлголт өгөх учиргүй бөгөөд байгалийн баялгийн ач холбогдлыг бууруулсан ямар нэг утга агуулаагүй байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд хүний нөөцийн хийгээд үйлдвэрлэсэн капиталын эзлэх хувь их байгаа нь байгалийн нөөцийн хувийг бууруулж байгаа юм. Тухайлбал, Канад улсын хувьд нэг хүнд ногдох байгалийн нөөц баялаг нийт баялгийн 11 хувьтай тэнцэж байна.

Нэг. Байгалийн нөөц баялаг

Хүрээлэн буй орчны нөөц баялагт агаар мандал, ан амьтан, шувуу, ургамал, усны сав газар зэргийг оруулдаг бол үл сэргээгдэх нөөц баялагт газрын тос, нүүрс, байгалийн хий, металл зэргийг оруулдаг байна. Аж үйлдвэржсэн орнуудын хийгээд хөгжиж буй улс орнуудын аль алинд нь эдийн засгийн хөгжил, тэр дундаа газар тариалангийн салбарын хөгжил нь хүрээлэн буй орчны нөөц баялагт тулгуурладаг байна. Байгалийн нөөц баялаг нь бусад капиталын нэгэн адил эдийн засаг дах үйлчилгээний урсгалд тодорхой хувь нэмрээ оруулдаг. Энэ нь түүхий эд, материал, эрчим хүч зэрэг үйлчилгээгээр дамжин эдийн засагт шууд утгаараа хүрч байхад эцсийн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болж очих нь ч бий.

Дээр дурьдагдсан эцсийн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний эдийн засгийн үнэ цэнэ, өртгийг тооцох нь хүрээлэн буй орчны эдийн засгийн дүн шинжилгээний гол зорилго юм. Байгалийн нөөц баялгийн эдийн засгийн үнэ цэнийг тооцож, түүнийг мөнгө, хөрөнгө болгоход хэд хэдэн аргыг ашигладаг байна.

Байгалийн бүх нөөц баялгийн эдийн засгийн үнэ цэнийг тооцож гаргана гэдэг нилээд том асуудал учир эхлээд үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа байгалийн баялгийг үндэсний баялгийн эх үүсвэр хэмээн тодорхойлон тооцоондоо ашигласан байна. Тухайлбал, газар нь газар тариалан хийгээд мал аж ахуйн салбарын эх үүсвэр, ой модыг банз, модны үйлдвэрлэлд, газар доорхи баялгийг металл хийгээд ашигт малтмалын болон түлш шатахууны үйлдвэрлэлийн эх үүсвэр болгон авч үзсэн. Мөн түүнчлэн, ой модны үйлдвэрлэлд ашиглагддаг байгалийн нөөцийг олборлох болон үл олборлох эх үүсвэр гэж ангилж авч үзсэн байна.

Байгалийн нөөц баялаг хийгээд түүний төрөл, өртгийг тодорхойлон гаргаснаар эдийн засгийн түрээс гэсэн үзэл баримтлалыг ашиглан байгалийн баялгийн өртгийг тооцохыг оролдсон байна. Хөрөнгийн капиталын өртөг гэдэг нь үйлчилгээний урсгалын өнөөгийн өртгийг хэлэх бөгөөд ашиглалтынхаа туршид бий болдог байна. Энэхүү үйлчилгээний урсгал дээр үндэслэн байгалийн баялгийн нөөцийг тооцох аргыг ашигласан байна.

Байгалийн баялгийн тогтвортой менежментийн асуудлыг авч хэлэлцэхэд тухайн үеийн өртгийг хэрхэн сонгож тооцоонд оруулах нь чухал юм. Байгалийн баялгийг боловсруулан ашиглаж болох хийгээд боловсруулах боломжгүй баялгийн ашиглалт, байгалийн баялгийг үйлдвэрлэлийн орц болгон ашиглах зэрэг нь тогтвортой эсвэл тогтвортой бус аль ч утгаар ойлгогдож болно.

Бууруулах хувь хэмжээ: Байгалийн баялгийн тухайн үеийн өртгийг тооцоход бууруулах хувийг сонгох асуудал хамгийн чухал ажлын нэг юм. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн үзүүлэлтүүдийг сонгох нь илүү тохиромжтой гэсэн хандлага, зөвлөмжүүд байдаг.

Уг өгөөжийг $s = r + \mu c$ гэсэн томъёогоор тооцно.

Энд r нь үр ашгийн өнөөгийн үнэ цэнэ (хүмүүс ирээдүйн ашгаас өнөөгийхийг илүүд үздэг), μ нь хэрэглээний нэмүү өртгийн мэдрэмж c нь нэг хүнд ногдох хэрэглээний өсөлтийн хувь болно.

Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн хувь гэдэг орон бүрт өөр байдаг учир тооцоонд стандарт 4 гэсэн бууруулах хувийг ашигласан байна, учир нь энэхүү туршилт тооцооны үндсэн зорилтын нэг нь улс орнууд хооронд харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэх явдал юм.

Хөдөө аж ахуйн тариалангийн талбай: Нөхөн сэргээгдэх нөөц баялаг гэдэг утгаар нь биш газрын чанарт нь анхаарч зөв зохистой менежментээр ашиглах ёстой. Тэр дундаа хүн амын ихэнхи хэсэг нь газар тариалан, бэлчээрийн аж ахуй эрхэлдэг улс орнуудын хувьд зөв зохистой менежмент хэрэгжүүлэх нь хамгийн чухал юм. Гэтэл энэхүү судалгааны дүнгээс харахад эдийн засгийн хувьд буурай хөгжилтэй орнуудад байгалийн баялгийн 80 аас илүү хувийг газар тариалан, бэлчээрийн газар эзэлж байна.

Улс орны түвшний газар тариалангийн газрын үнийн мэдээлэл хангалттай хэмжээнд нийтлэгдээгүй байдаг учраас газрын баялгийн өртгийг тооцох аргачлал зайлшгүй шаардлагатай. Орон нутгийн түвшинд газрын үнийн талаарх мэдээлэл байгаа тохиолдолд ч газрын зах зээл нь нилээд сүйтгэгдсэн байдаг тул нийт улс орны түвшинд бодитой харьцуулалт хийгдэнэ гэдэг эргэлзээтэй асуудал юм..

Тиймээс газраас авах бүтээгдэхүүн буюу өгөөж нь дэлхийн зах зээлийн үнээр худалдаалагдана гэж үзэн газрын түрээсийн тухайн үеийн хямдарсан өртөгт суурилан газрын өртгийг тооцсон байна. Ингэхдээ үр тариа-эрдэнэ шиш, улаан буудай, цагаан будаа гэсэн 3 гол бүтээгдэхүүнийг сонгон авч дэлхийн зах зээлийн үнээр үнэлсэн байна. Үр тариа 34 хувь, улаан буудай 31 хувь, цагаан будаа 50 хувийг эзэлнэ хэмээн дурьдсан Дэлхийн банкны ХАА-н салбарын тайлангаас авсан боловч энд ажиллах хүч, бордооны эзлэх хувийг оруулаагүй байна.

Бэлчээрийн газар: Бэлчээрийн газрын өгөөжийг МАА-н бүтээгдэхүүн буюу хонь болон үхрийн үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол байна хэмээн төсөөлж тооцсон байна. Дунджаар үйлдвэрлэлийн зардал нь орлогын 55 хувь гэж үзвэл бэлчээрийн газраас өгөх үр ашгийг нийт үйлдвэрлэлийн 45 хувь байна гэж үзсэн. Сүү, үхэр, хонь, ямааны мах болон ноосыг олон улсын зах зээлийн үнээр үнэлж үйлдвэрлэлийн хэмжээг гаргасан байна.

Модны нөөц: Ойн эдийн засгийн гол хэрэглээ бол модны нөөц юм. Модны үйлдвэрлэлийг тооцохдоо ой модны түрээсийг (үнээс хасах нь үйлдвэрлэлийн дундаж зардал) тооцож дараа нь бууруулах хувийг 4-өөр тооцож үнэлсэн. Хэрэв модны үйлдвэрлэл жилийн цэвэр орлогоос их байвал, дуусах хугацааг ойн талбайн хэмжээг үйлдвэрлэл болон орлогын зөрүүнд хувааж тооцно. Модны хэмжээг нийт ойн талбайн 80 хувиар авч

халуун орны болон халуун орны биш ойн талбайн ойн эзлэхүүнд харьцуулсан хүчин зүйлийн хэмжигдэхүүнээр үржүүлж тооцсон байна.

Модны бус ойн нөөц: Ойн орлого дан ганц модны орлогоос бүрдэхгүй. Энд ойн бүтээгдэхүүн, ан агнуур, загасчлал, амралт зугаалга орно. Энэ нь хөгжингүй болон хөгжиж байгаа орны хувьд ялгаатай байдаг, хөгжингүй орны хувьд нэг жилд нэг гектар ойн талбайгаас олох орлого 145 ам.доллар байдаг бол хөгжиж байгаа орны хувьд 112 ам.доллар байдаг гэсэн судалгаа байдаг. Нийт ойн зөвхөн 10 хувиас энэхүү орлогыг олдог гэж төсөөлөн нэг гектар талбайгаас олох орлогыг орон бүрийн ойн аравны нэгээр үржүүлж тооцсон байна.

Дархан цаазтай газар: Дархан цаазтай газар бол амралт, зугаа цэнгэлийн үнэ цэнээр тооцогдоно. Үүнийг гаргах гол эх үүсвэр бол аялал жуулчлалын мэдээлэл юм.

Газар доорхи баялаг: Металл, эрдэс баялаг, газрын тос, нүүрс болон хий нь газрын тосны нөөцөөр баян Саудын Араб, Норвеги, Мексик зэрэг улсуудад болон эрдэс баялгаар баян Өмнөд Африкт байгалийн нөөц баялгийн томоохон хувийг эзэлдэг. Эдгээр баялгийг эдийн засгийн өнөөгийн үнэ цэнээр (үйл ажиллагааны цэвэр ашгаас үйлдвэрлэсэн хөрөнгийн хэвийн үр ашгийг хасч) нь тооцсон байна. Уг тооцооллыг хийхэд нэлээд бодит төсөөлөл шаардлагатай. Нөөцийн түрээсийг тогтмол гэж үзэн дараахи томъёогоор тооцсон:

$$V(0) = \pi_0 q_0 \cdot \left(1 + \frac{1}{r}\right) \left(1 - \frac{1}{(1+r)^{T_0}}\right)$$

Энд $V(0)$ нь нийт газар доорхи баялаг, π_0 нь нэгж нөөцөд ногдох түрээсийн хэмжээ, q_0 нь 5-аас дээш жилд дуусч болох нөөцийн үйлдвэрлэл, T_0 нь дуусах хугацаа, r нь бууруулах хувь хэмжээ болно.

Хоёр. Үйлдвэрлэсэн хөрөнгө

Үйлдвэрлэсэн хөрөнгө буюу биет хөрөнгө нь саяханыг хүртэл үндэсний эдийн засгийн төлөвлөлтийн анхаарлын төвд нь байсан. Хөрөнгийн хуримтлалын өндөр хувь хэмжээ болон хуримтлалын тохиромжит хувь хэмжээг хэтэрхий онцгойлон авч үзсэнээр биет хөрөнгө бол хөгжилд саад болно гэж үзэгддэг байсан. Гэсэн хэдий ч биет хөрөнгө нь үйлдвэрлэлийн гол хүчин зүйл яах аргагүй мөн боловч заавал хязгаарлах хүчин зүйл биш бөгөөд байгалийн нөөц баялаг нь энэхүү үүргийг гүйцэтгэдэг. Жишээ нь загасны аж ахуйн хувьд загасны хэмжээг тооцох боломжтой байхад харин загасчлах завийг тооцоход бэрхшээлтэй байдаг. Бүс нутаг бүрийг харьцуулан үзэхэд үндсэн хөрөнгийн нийт үндэсний баялагт эзлэх хувь хэмжээ нь ойролцоо байсан байна. Хамгийн өндөр нь ЭЗХАХБ-ын болон Номхон далайн орнуудынх 30 хувьтай байсан бол бага нь Зүүн Ази болон Төв Америкт 15 хувьтай байна. Харин бүс хоорондын хүний нөөц дэх хэлбэлзэл дэндүү их байсан байна.

Тооцооны арга зүй: Үйлдвэрлэсэн хөрөнгө нь машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж болон хотын газрыг хамрах ба байгалийн нөөц баялгийн үнэлгээ нь үйлдвэрлэсэн хөрөнгийн үнэлгээтэй нэлээд холбоотой байдаг. Үйлдвэрлэсэн хөрөнгийн тооцоо нь хөрөнгө оруулалтын хувь хэмжээнээс эргэлтийн хөрөнгийг тооцдог арга дээр үндэслэн хийгдсэн байна.

1990 оны үндсэн хөрөнгө нь тухайн орны 1987 оны суурь үнээр байсан бөгөөд 1990 оны ам.доллар руу шилжүүлэхдээ 1987 оны валютын ханш болон АНУ-ын ДНБ-ий дефляторыг ашигласан. Дараа нь 1990 оны тооцоог 1994 он рүү тухайн тайлант оны оны үнээрх дотоодын нийт хөрөнгө оруулалтыг өмнөх оных дээр нь нэмж, элэгдлийг нь хасах замаар экстраполяци хийсэн байна. 1990 он хүртэлх хөрөнгийн элэгдлийг тооцохдоо адил төстэй үндсэн хөрөнгийн мэдээллийн санг ашигласан бөгөөд 1994 он рүү экстраполяци хийхдээ тухайн орны үндсэн хөрөнгийн элэгдэл ҮНО-ын харьцаа нь 1980-1990 оны дундаж харьцаатай ижил хэмээн үзэж тооцоолсон байна.

Тухайн улсуудын биет хөрөнгө бүгд арилжааны биш шинж чанартай байсан тул эдгээрийг салгаж тооцсон. Арилжааны биш шинж чанартай хөрөнгийг худалдан авах чадварын паритетын /PPP/ валютын ханшаар, харин арилжааны чанартай хөрөнгийг валютын нэрлэсэн ханшаар үнэлсэн байна.

Барилга байгууламж = S *үйлдвэрлэсэн хөрөнгө*(ХАЧП/валютын нэрлэсэн ханш)

Машин, тоног төхөөрөмж = $(1-S)$ *үйлдвэрлэсэн хөрөнгө

Хотын газар = S *үйлдвэрлэсэн хөрөнгө*(ХАЧП/валютын нэрлэсэн ханш)* U

Энд S - барилга байгууламжийн үйлдвэрлэсэн хөрөнгөд эзлэх хувийн жин, U - хотын газар, барилга байгууламжийн харьцаа болно. Эдгээр хувиудыг 72 болон 33 хувь гэж тус тус таамагласан байна.

Мэдээллийн эх үүсвэр: Биет хөрөнгийн тооцоог Дэлхийн Банкны Олон улсын эдийн засгийн газрын Хөгжлийн талаархи тоо мэдээллийн хэлтсээс хийсэн тооцоогоор авчээ. ДНБ-ий дефляторыг Олон улсын санхүүгийн статистикийн мэдээллийн сангаас, оны үнээрхи дотоодын нийт хөрөнгө оруулалтыг Дэлхийн банкны Үндэсний тооцооны мэдээллийн сангаас тус тус авсан байна.

S болон U -г Канадын Статистикийн газраас 1985 онд гаргасан Канадын эдийн засгийн үндэсний актив пассивын тэнцэл дээр тулгуурлан тооцжээ. Энэхүү балансаар үйлдвэрлэсэн хөрөнгийн 72 хувийг барилга, байгууламж эзэлж байсан бөгөөд ингэхдээ хотын газар барилга байгууламжийн харьцаа 33 хувь байсан байна. Канад бол газар нутгаар том орон бөгөөд Канадын актив пассивын тэнцэл бол дэлхий дээрхи хамгийн нарийвчилсан үзүүлэлттэй тэнцэл юм байна. ХАЧП-ын валютын

ханшийг Дэлхийн Банкны Олон улсын эдийн засгийн газрын Хөгжлийн талаархи тоо мэдээллийн хэлтсээс авчээ.

Гурав. Хүний нөөц

Хүний нөөцийн үр ашгийн үнэлгээг хийх нь үндэсний баялгийн үнэлгээний хамгийн хүндрэлтэй, маргаантай тал юм. Энэд боловсролын үр ашгийн талаар голлон анхаарах учраас “хүмүүн капитал” гэдгээс илүү “хүний нөөц” гэдэг нэр томъёог хэрэглэдэг. Илүү өргөн хүрээнд авч үзэхийн тулд үндэсний баялгийн үнэлгээ нь боловсрол, ур чадваргүй ажиллах хүч болон “нийгмийн капитал” (нийгмийн байгууллагын болон бусад нийгмийн бүтэц бүрэлдэхүүний бий болгосон өртөг-нийгмийн капиталын талаарх үзэл баримтлалын илүү дэлгэрэнгүй тайлбарыг “Баялгийн үнэлгээг өргөтгөх нь” (Дэлхийн банк 1997 он) номын 6 дугаар бүлэг)-ын үр ашгийн өртөгт чиглэгдэх болно.

“Хөгжил” гэдэг нь үйлдвэрлэсэн хөрөнгийн хуримтлалтай ижил утгатай байсан бол одоо үед хөгжлийн үйл явц дахь хүний нөөцийн ач холбогдлыг онцолж үздэг болсон. Хөгжлийн үр нөлөөг бий болгох боловсрол, сургалтын зардал, эрүүл мэндийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт үүний нэг баталгаа болдог. Түүнээс гадна дээрхи зардлын үр ашиг нь ирээдүйд орох орлогыг бий болгодог. Үйлдвэрлэл дэх хүний хүчин зүйлийн чанарыг сайжруулснаар бодит капиталын хөрөнгө оруулалтын нэгэн адил чухал ач холбогдолтой юм.

Тооцооны арга зүй: Хүний нөөцийн үнэлгээг Норвеги улс (Норвегийн Статистикийн төв товчоо, 1992 он) анхлан хийсэн ба үлдэгдлийн аргыг ашигласан байна. Энэ дагуу дараахи гурван үе шатанд тооцоололтыг хийжээ. Үүнд (1) байгалийн нөөцөөс орох орлогыг ҮЦБ-ээс салгана (2) нөөцийн бус ҮЦБ-ий өнөөгийн өртгийг хүн амын үр бүтээлтэй амьдралын үлдсэн жилүүдийн дунджаар авна (3) нөөцийн бус ҮЦБ-ий өнөөгийн өртгөөс үйлдвэрлэсэн хөрөнгийн өртгийг хасч хүний нөөцийн өртгийг тооцно. Эдгээр тооцоог дараахи тэгшитгэлийн системээр харуулбал:

R = өнөөгийн өртөг (хөдөө аж ахуйн салбарын цалин + хөдөө аж ахуйн бус ҮНБ – газрын түрээс – элэгдэл хорогдлын шимтгэл)

K_p = барилга байшин, машин тоног төхөөрөмжийн үлдэгдэл өртөг

Хүний нөөцийн өртөг = (R - K_p – хотын газрын өртөг) * (PPP/нэрлэсэн валютын ханш)

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг дэх цалингийн эзлэх хувийг хөдөө аж ахуйн салбарын тайлангийн газар тариалангийн төсвийн мэдээлэл (Дэлхийн банк, 1992 он)-д үндэслэн 45 хувиар авсан. ДНБ болон ҮНБ дэх хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувийн мэдээллийг *Дэлхийн хөгжлийн үзүүлэлт* (Дэлхийн банк, 1996 он)-ээс авсан байна. Энэхүү хөдөө

аж ахуйн салбарын ДНБ гэсэн мэдээлэлд ойн аж ахуй, загас агнуурын үйл ажиллагаа орж байгаа учир ҮНБ-ээс үлдсэн нөөцийн түрээс нь газрын түрээс болж байгаа юм.

Өнөөгийн өртгийг тооцох зорилгоор үр бүтээлтэй амьдралын үлдэх жилийн тоо нь 65 эсвэл нэг наснаас хойших дундаж наслалтаас хүн амын насны дунджийг хасч тооцогдоно. Насны дунджийг хүн амын насны тархалтын талаарх мэдээллийг ашиглан тооцно. 65 нас болон нэг наснаас хойших дундаж наслалтын утга нь 65-аас дээшхи насны хүмүүс цаашид удаан амьдарч, хийж бүтээж чадахгүй гэсэн таамаглалд үндэслэгддэг. Жишээлбэл, Энэтхэг улсад нэг наснаас хойших дундаж наслалт 61, хүн амын насны дундаж нь 27 бол үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрлөх үлдэх нас нь 34 байна. Швед улсад нэг наснаас хойших дундаж наслалт нь 78 ба хүн амын насны дундаж нь 40 байдаг байна. Үр бүтээлтэй ажиллаж амьдрах насны дээд хязгаарыг дундаж наслалтаар бус 65 насыг авбал үлдэх насны доод хязгаар нь 25 байна. Олонхи хөгжиж буй орнуудад эхний жилд нас барах магадлал хамгийн өндөр байдаг учир төрснөөс хойших насыг биш нэг наснаас хойших дундаж наслалтыг авахыг анхаарах хэрэгтэй.

Арилжааны биш шинж чанартай үйлдвэрлэсэн хөрөнгө нэрлэсэн валютын ханшаар бус худалдан авах чадварын паритет (PPP)-ээр үнэлэгдэж байгаа. Хүний нөөцийн өртөг нь хүний нөөцийн өгөх үр өгөөжийн ашиглагдах боломжийг тусгах зорилгоор ХАЧП валютын ханшаар үнэлэгдэх ёстой.

Үндэсний баялгийн тооцоонд эзэмшлийн асуудал чухал байдаг учраас баялгийн тооцоо нь цэвэр үндэсний бүтээгдэхүүн (ҮНБ-ээс хасах нь үйлдвэрлэсэн хөрөнгийн элэгдэл)-ээс эхэлнэ. Хүний нөөцийн өртгийг тооцох үлдэгдлийн арга нь хилийн чанад дахь үндэсний үйлдвэрлэлээс орж ирсэн цалин, хөрөнгийн орлогын цэвэр урсгалын зарим хэсэг нь үйлдвэрлэсэн хөрөнгөд шууд хамааралтай байх учраас ихээхэн зөрүүтэй байдаг. Хилийн чанад руу цалин, хөрөнгийн орлогын гарах цэвэр урсгалтай орнуудын хувьд үйлдвэрлэсэн хөрөнгийн өртөг нь илүү тооцогддог ба хүний нөөцийн өртөг нь үндэсний баялгийн тооцоонд дутуу тооцогддог байна.

Хүний нөөцийн өртгийг үнэлэх үлдэгдлийн арга нь олон төрлийн таамаглалыг дэвшүүлдэг учир үнэлгээний үр дүнг баримтаар нотлох нь их чухал юм. Хүмүүн капитал нь гарцаагүй хүний нөөцийн өртгийн хамгийн том бүрдэл хэсэг болно. Хэрэв үлдэгдлийн арга нь ойлгомжтой байвал хүний нөөцийн өртгийн тооцооны үр дүн нь янз бүрийн улс орны хүмүүн капиталын тоо хэмжээний хамааралгүй тооцоололттой ихээхэн хамааралтай байх ёстой.

Үндэсний тооцооны систем-2008 аргачлалыг бүрэн нэвтрүүлэх хүрээнд манай орны хувьд үндэсний баялгийн хэмжээг тооцох арга зүйг боловсруулж, мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, холбогдох тооцоо,

судалгааг хийх нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад нэн шаардлагатай мэдээлэл байх болно.

Дүгнэлт

Байгалийн нөөц баялаг, хүмүүн болоод нийгмийн капитал, үйлдвэрлэсэн хөрөнгөөс бүрдсэн “үндэсний баялаг” хэмээх ойлголт XVII зууны эцэс, XVIII зууны эхэн үед У.Петти, А.Смит, Г.Кинг болон бусад эдийн засагчдын бүтээлүүдэд тусгагдаж эхэлсэн юм.

Үндэсний баялгийг тодорхойлох нь улс орны эдийн засгийн чадавхийг бодитоор үнэлэх маш чухал ач холбогдолтой бөгөөд НҮБ-ын ҮТС-93 аргачилсан зөвлөмжид цэвэр өртгөөр нь санхүүгийн болон санхүүгийн бус гэсэн 2 төрлөөс бүрдэх эдийн засгийн нийт хөрөнгө - үндэсний баялгийн үзүүлэлтүүдийг тооцох талаар тодорхой заасан байдаг. Тухайлбал уг аргачилсан зөвлөмжид “*Үндэсний баялаг* нь эдийн засгийн нэгжүүд (бие хүн, хуулийн этгээд) эзэмшдэг, өөрийн эзэмшигчиддээ эдийн засгийн ашгийг өгдөг үйлдвэрлэгддэггүй болон санхүүгийн хөрөнгийн зэрэгцээ хүний хөдөлмөрийн үр дүн, газар, бусад байгалийн баялаг зэрэг хуримтлагдсан материаллаг баялгаас бүрддэг” гэсэн байна.

Үндэсний тооцооны систем-2008 аргачлалыг бүрэн нэвтрүүлэх хүрээнд манай орны хувьд үндэсний баялгийн хэмжээг тооцох арга зүйг боловсруулж, мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, холбогдох тооцоо, судалгааг хийх нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад нэн шаардлагатай мэдээлэл байх болно.

Ашигласан ном зүй

1. Kunte, Arundhati, Kirk Hamilton, John Dixon, Michael Clemens, 1998, “Estimating National Wealth: Methodology and Results, Indicators and Environmental Valuation”, The World Bank.